

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/100/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	9
4.1 Ерөнхий зүйл .....	9
4.2 Материаллаг байдал .....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11
5.1 Зөвлөмж.....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 268

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ХЭРЛЭН СУМЫН ЯГААН ЦЭЭНЭ  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Ч.АЗЗАЯА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020379

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	406,789,061.04	226,329,112.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,191,329.59	60,816,046.12
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5.00	2,839.00
31110	Төгрөг	5.00	2,839.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,191,324.59	60,813,207.12
3121	Төгрөг	27,191,324.59	60,813,207.12
31213	Арилжааны банк дахь харилцах	27,191,324.59	60,813,207.12
33	АВЛАГА	270,222,451.65	1,869,770.67
33401	Дансны авлага /ТӨҮГ/	270,222,451.25	1,869,770.27
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	0.40	0.40
35	БАРАА МАТЕРИАЛ	109,375,279.80	163,643,295.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,191,000.00	404,909.00
354	Хангамжийн материал	52,487,745.80	94,553,215.80
35410	Бичиг хэргийн материал	736,200.00	2,300,100.00
35420	Аж ахуйн материал	51,751,545.80	92,253,115.80
35600	Мал амьтад	53,696,534.00	68,685,170.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	290,524,777.26	316,572,718.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	290,524,777.26	316,572,718.70
391	Газар	30,625,000.00	30,625,000.00
392	Биет хөрөнгө	259,899,777.26	285,947,718.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	194,741,881.56	194,741,881.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,989,670.27)	(21,226,925.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,500,000.00	12,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,180,666.67)	(8,264,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,090,574.56	188,367,202.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,605,764.97)	(102,073,674.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,259,370.00	44,067,370.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,915,946.96)	(22,164,134.86)
39301	Програм хангамж	445,867.00	445,867.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(445,867.00)	(445,867.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	697,313,838.30	542,901,830.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	-
413	Өглөг	(0.00)	-
4136	Бусад өглөг	(0.00)	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	697,313,838.31	542,901,830.89
51	Засгийн газрын хувь оролцоо	697,313,838.31	542,901,830.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	213,288,191.80	213,288,191.80
51101	Өмч: - төрийн	213,288,191.80	213,288,191.80
512	Хуримтлагдсан үр дүн	383,340,060.95	228,928,053.53
51210	Өмнөх үеийн үр дүн	58,769,889.86	383,340,060.95
51220	Тайлант үеийн үр дүн	324,570,171.09	(154,412,007.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,685,585.56	100,685,585.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	697,313,838.31	542,901,830.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	697,313,838.30	542,901,830.89

**Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,328,381,630.86	1,319,641,806.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,078,710,680.86	198,406,790.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,078,710,680.86	198,406,790.40
120009	Бусад орлого	1,078,710,680.86	198,406,790.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,249,670,950.00	1,121,235,016.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	438,976,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	438,976,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	810,694,950.00	1,121,235,016.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	810,694,950.00	1,121,235,016.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,003,811,459.78	1,474,053,813.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,966,024,559.78	1,474,053,813.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,966,024,559.78	1,462,053,813.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	525,818,686.00	730,796,713.37
210101	Үндсэн цалин	525,818,686.00	730,796,713.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,620,803.12	93,014,207.79
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	62,620,803.12	93,014,207.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,785,545.09	9,715,719.85
210301	Гэрэл, цахилгаан	7,301,542.09	8,207,833.25
210303	Цэвэр, бохир ус	-	649,218.60
210304	Байрны түрээс	1,484,003.00	858,668.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,607,096.00	72,647,695.95
210401	Бичиг хэрэг	8,720,857.00	26,653,124.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,819,160.00	3,358,700.31
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	36,181,996.64
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	5,067,079.00	6,453,875.00
2105	Нормативт зардал	1,243,287,366.11	445,174,920.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,243,287,366.11	445,174,920.40
2107	Томилолт, зочны зардал	2,890,000.00	8,429,600.00
210702	Дотоод албан томилолт	2,890,000.00	8,429,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,964.00	599,063.90
210803	Даатгалын үйлчилгээ	-	424,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	23,936.00	23,936.00
210807	Газрын төлбөр	50,328.00	50,328.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	92,700.00	100,299.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,848,099.46	101,675,892.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,370,827.08	57,442,086.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	972,800.00	3,197,120.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,504,472.38	41,036,686.56
211	ХҮҮ	-	12,000,000.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	12,000,000.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	-	12,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,786,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	37,786,900.00	-
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	37,786,900.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	324,570,171.08	(154,412,007.42)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	324,570,171.08	(154,412,007.42)

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,019,939,834.00	1,391,958,816.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,622,684.00	2,370,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,622,684.00	2,370,000.00
120009	Бусад орлого	38,622,684.00	2,370,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	981,317,150.00	1,389,588,816.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	438,976,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	438,976,000.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	542,341,150.00	1,389,588,816.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	542,341,150.00	1,389,588,816.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	995,350,742.09	1,303,314,465.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	995,350,742.09	1,303,314,465.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	995,350,742.09	1,303,314,465.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,051,913.01	541,357,562.21
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	455,051,913.01	541,357,562.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,832,842.70	160,831,392.21
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	117,832,842.70	160,831,392.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,719,602.14	87,295,631.75
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	38,719,602.14	87,295,631.75
2104	Хангамж, бараа материалын зардал	339,489,330.00	441,394,505.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	5,127,079.00	6,726,475.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	334,362,251.00	434,668,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,257,054.24	72,435,374.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	43,018,054.24	60,010,874.00
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	-	424,500.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1,239,000.00	12,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,589,091.91	88,644,350.83
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	5,303,817.52	20,962,894.70
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	5,303,817.52	20,962,894.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,315,456.00	75,982,329.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,315,456.00	75,982,329.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,315,456.00	75,982,329.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	11,315,456.00	75,982,329.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,011,638.48)	(55,019,434.30)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,577,453.43	33,624,916.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,613,876.16	27,191,329.59
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,191,329.59	60,816,046.12

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	58,769,889.87	372,743,667.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	58,769,889.87	372,743,667.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	324,570,171.08	324,570,171.08
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	383,340,060.95	697,313,838.31
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	383,340,060.95	697,313,838.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	383,340,060.95	697,313,838.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(154,412,007.42)	(154,412,007.42)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,288,191.80	100,685,585.56	228,928,053.53	542,901,830.89

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Зорилго: Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж өрх, иргэн бүрт нийгмийн болон эрүүл мэндийн анхан шатны түргэн тусламжийн үйлчилгээг ур чадварын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зөв дадлыг эзэмшүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154.4 сая төгрөгөөр буюу 22.1 хувиар буурсан байна.

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,191.3	60,816.0	33,624.7
Авлага	270,222.5	1,869.8	(268,352.7)
Бараа материал	109,375.3	163,643.3	54,268.0
Үндсэн хөрөнгө	290,524.8	316,572.7	26,047.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>697,313.8</b>	<b>542,901.8</b>	<b>(154,412.0)</b>
Өр төлбөр	(0.0)	-	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	697,313.8	542,901.8	(154,412.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>697,313.8</b>	<b>542,901.8</b>	<b>(154,412.0)</b>

Авлага 268.3 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал данс 163.6 сая төгрөг болж 54.2 сая төгрөгөөр өссөн нь байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулахад холбоотой түүхий эд материал, хангамжийн материал худалдан авалт гол нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө нийт 26.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд 67.0 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацаанд 41.0 сая төгрөгийн элэгдэл тооцсон нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 542.9 сая төгрөг болж 154.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдалтай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслийг нэг иргэнд тооцсон санхүүжилт, тохиолдлоор тооцсон тусламж үйлчилгээний санхүүжилт, байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн төлөвлөсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас нийт 1,389.6 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,303.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Ягаан цээнэ Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,474.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 22.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Илрүүлэлт:** Тус өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2022.01.17-ны өдрийн А/03 тоот тушаалаар 2022 оны 1-р сараас ажилчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоож нэмэгдүүлсэн бөгөөд ингэхдээ 2022.03.01-ээс мөрдөгдөж эхлэх 2022.03.09-нд батлагдсан Засгийн Газрын тогтоолыг үндэслэл болгосон. Мөн тус ЭМТ-ийн даргын үндсэн цалин тушаал дээрх дүнгээс 200.000 төгрөгөөр илүү бодож олгосон. Энэ нь Засгийн газрын тогтоолыг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацаанаас өмнөх хугацаанд буюу буцаан хэрэглэсэн нь хуульд нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аливаа тушаал, шийдвэр гаргахдаа хуль тогтоомжийн хүрээнд гаргаж байх, хүчин төгөлдөр эсэх, мөрдөж эхлэх хугацаанд уялдуулж байх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд түүвэрт хамрагдсан тул аудитаар ороогүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн худалдан авалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг холбогдох хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 8.3 сая төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс зөвлөмж хүргүүлсэн.

#### 5.1 Зөвлөмж

1. **Илрүүлэлт:** Тус байгууллагын үйлчилгээнд ашигладаг автомашины шатахууныг талоноор олгодог бөгөөд шатахууны талоныг худалдан авсан нийт дүнгээр төлбөр төлсөн үед зардалд бүртгэдэг байна. Тайлант хугацаанд 6.4 сая төгрөгийн шатахууны толон худалдаж авч зарцуулсан бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” гэсэн заалтад нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Шатахууны талоныг худалдан авсан үед хөрөнгийн тусдаа данс нээж орлогод авч жолоочид толон олгох үед данснаас зарлагадах, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж нормыг шинэчлэн тогтоох.

2. **Илрүүлэлт:** Эрдэнэс тавантолгой ХК-ийн хувьцааг авахаар төлсөн гэх 1.9 сая төгрөгийн авлагатай бөгөөд хувьцааг эзэмшээгүй, уг тооцоотой холбоотой үлдэгдлийг баталгаажуулаагүй.

**Шийдвэрлэсэн:** Уг тооцоотой холбоотой авлагыг баталгаажуулах, хувьцааг эзэмшсэн тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн тооцооны төвд үнэт цаасны данс нээлгэж баталгаажуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг 2023 оны 5 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны талоны мөнгийг төлсөн үед шатахууны зардалд бүртгэсэн, Мөн автомашины шатахууны нормыг өндөр тогтоосон (Приус 20 маркын автомашинд 100 км-т 12 л бензин зарцуулахаар тооцсон)	1	6,453.9					1	6,453.9				
Эрдэнэс тавантолгой ХК-ийн хувьцааг авхаар төлсөн мөнгөнд хувьцааг аваагүй, уг тооцоотой холбоотой үлдэгдлийг баталгаажуулаагүй.	1	1,868.3					1	1,868.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>8,322.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>8,322.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ӨЭМТ-ийн даргын 2022.01.17-ны өдрийн А/03 тоот тушаалаар 2022 оны 1-р сараас ажилчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоож нэмэгдүүлсэн бөгөөд ингэхдээ 2022.03.01-ээс мөрдөгдөж эхлэх 2022.03.09-нд батлагдсан Засгийн Газрын тогтоолыг үндэслэл болгосон. Мөн тус ЭМТ-ийн даргын үндсэн цалин тушаал дээрх дүнгээс 200.000 төгрөгөөр илүү бодож олгосон.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>